

26

ТАВАН ТОЛГОЙ ХК-ИЙ 2014 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгийн эзэд та бүхний энэ өдрийн мэндийг эрэн мэндчилж байна.

Тавантолгой ХКомпани 2014 онд ТЭЗҮ, УАТөлөвлөгөө, Орон нутгаас өгсөн ерөнхий чиглэлийн дагуу 2 сая тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажиллаа. Хэдийгээр нүүрсний зах зээлийн хямралтай байсан ч 645,5 мян.тн нүүрс олборлон 554,5 мян.тн нүүрсийг экспортод, 91 мян.тн нүүрс дотоод зах зээлд нийлүүлэн нүүрсний төлөвлөгөөний биелэлт 32,2 хувьтай байлаа. Үндсэн үйлдвэрлэлийн хүрээнд дан ганц нүүрс олборлолт явуулхын зэрэгцээ зогсонги байсан коксын үйлдвэрийг сэргээж 233 тн кокс боловсруулж дотоодын зах зээлд борлуулж ажиллаа. Дотоодод борлуулсан нүүрсний 6285,65 тн-ийг Өмнөговь аймгийн төвийн нүүрс борлуулах цэгээр борлуулсан ба 21044,1 тн нүүрсийг 10%-ийн хямдралтайгаар хэрэглэгчдэд борлуулсан байна.

2014 онд туслан гүйцэтгэгч компаниудаар нийт 4,7 сая м3 хөрс хуулж, 645,5 мян.тн нүүрс борлуулан 300 гаруй мянган тн нүүрс авахад бэлэн нөөцтэй байсан бөгөөд нийт 5.2 сая м3-ийн уулын цулын ажил гүйцэтгэж, хөрс хуулалтын коэффициентийг 4,7-д барьж ажилаа.

2014 онд нийт 30,8 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдэн 24,7 тэрбум төгрөгийн зардал гаргаж 3,6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаа. Борлуулалтын үйл ажиллагааны үр дүнд улс болон орон нутгийн төсөвт нийт 10,2 тэрбум төгрөгийн татвар хураамж төвлөрүүлсэн байна. Үүнээс:

1. ААНОАТатвараар 5,2 тэрбум төгрөг
2. АМНАТөлбөрөөр 4,3 тэрбум төгрөг
3. НӨАТатвараар 1,4 тэрбум төгрөг
4. Агаар бохирдлын Татвараар 514,3 сая төгрөг
5. ХАОТатвараар 546,4 сая төгрөг эзэлж байна.

Мөн 2013 оны ногдол ашгийн 40,3 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчидэд олгож байна. Тавантолгой ХК нь 2014 оныг 177 хүний бүрэлдэхүүнтэйгээр 5-н Албадын зохион байгуулалттайгаар ажиллаж ирлээ. Гүйцэтгэх захирлын ажлын хүрээнд нийт 291 тушаал шийдвэр гарган 19 ажилтан шинээр авч 16 ажилтан хууль тогтоомжид заасан заалтын дагуу өндөр насны тэтгэвэрт гарах болон өөрийн хүсэлтээр болон тодорхой зөрчлийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн байна. Тэтгэвэрт гарсан 4 ажилтанд дотоод журамд заасны дагуу 30 сая төгрөгийн тусламж үзүүлсэн. Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн хүрээнд 450 орчим ажилтныг ажлын байраар хангаж ажиллаа.

Өнгөрсөн оны нүүрсний зах зээлийн талаар мэдээлэл танилцуулахад:

2014 онд Монгол улсын нүүрсний зах зээл дээрх хямрал үргэлжилсэн хэвээр байсан ба улсын хэмжээнд 33,6 сая тонн нүүрс олборлохоор төлөвлөсөн боловч 19,5 сая тонн нүүрс олборлон борлуулж 58,2%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна. Түүнчлэн БНХАУ-д нүүрсний үнэ жилийн эхнээс 13,8 ам.доллараар буюу 20,2%-ийн бууралттай гарсан байна. Эдгээр үзүүлэлт нь манай компанийн борлуулалт нэмэгдэхгүй байх, худалдан авалтын хэмжээ бага байхад шууд нөлөө үзүүлсэн.

Компанийн хүний нөөц, сургалтын сурталчилгааны чиглэлээр:

2014 онд албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэжлийн түвшинд хүргэх зорилгоор нарийн мэргэжил, зэрэг дээшлүүлэх зэрэг сургалтанд 12 алба хаагчийг мэргэшүүлж сургасан.

Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах боловсон хүчний нөхөн хангалтыг бүрдүүлэх дотоод нөөц болоцоог ашиглан 20-н алба хаагчийг судлаж холбогодох ажлын байруудад томилон ажиллууллаа.

Ажилтан албан хаагчидад Өмнөговь аймгийн төрийн болон төрийн бус байгуулагуудтай хамтарсан сургалтыг 5-н удаа зохион байгуулан, давхардсан тоогоор 400-н алба хаагч хамрагдсан байна. Дотоодоос зохион байгуулсан сургалтыг сар бүр төлөвлөгөөний

227

дагуу зохион байгуулан алба хаагчдыг бүрэн хамруулж ажилсан байна. Түүнчлэн Оюутны тэтгэлэгт хөтөлбөрт компанийн алба хаагчидын 12 хүүхэд хамрагдаж 10 хүүхэд нь төрийн албан хаагчын хэмжээгээр, 2 оюутан нь 100%-н тэтгэлэгт хамрагдсан байна.

Алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор төлөвлөгөөт болон намрын спартакиад, байгууллагын аварга шалгаруулах тэмцээн уралдааныг зохион байгуулж ажиллаа.

Манай компанийн баг тамирчид аймаг болон бүсийн чанартай тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байрыг удаа дараа эзэлсэн амжилтаар арвин жил боллоо.

Олон нийттэй харилцах, иргэдийг үнэн бодит мэдээллээр хангах ажлын хүрээнд компанийн нээлттэй өдөрлөгийг Баяндалай, Цогт-Овоо, Цогтцэций, Манлай, Ханбогд, Баян-Овоо сумдад зохион байгуулж сум тус бүрийн уугуул иргэдийг татан оролцуулах, нөхөрсөг тэмцээн уралдаан зохион байгуулах, сурагч хүүхдүүдийн дунд уран илтгэл, зохион бичлэгийн уралдаанууд явуулан өргөн цар хүрээг хамрач үр дүн өндөртэй арга хэмжээ болсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажлын талаар :

Нэн түрүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудлыг эрхэм зорилго болгож ажилчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, ажлын хувцас хамгаалах хэрэгсэлийн хэрэглээ чанарыг сайжруулах, сургалт зааварчилгааг чанартай өгч байх тал дээр онцгой анхааран ажиллаж ирлээ. ХАБЭА-н Модуль 1 сургалтанд ажил олгогчийн төлөөлөл инженер, мастерууд болон ХАБ-ын ажилтан зэрэг нийт 9-н хүн хамруулснаар эрсдэлгүй ажиллах, ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг биелүүлэх тал дээр ахиц дэвшил гарган ажиллаа.

Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт явуулан техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавин, ажил хариуцагч ХАБ-н ажилтан нарт өдөр тутмын болон давтан зааварчилгааг тогтмол өгч байнгын ажлын уялдаатай ажилласанаар 2014 он ҮЙЛДВЭРИЙН ОСОЛГҮЙ ЖИЛ байлаа. 2014 онд ХАБЭА-н зардалд 210-н сая төгрөгийг зарцуулан шаардлагатай бүх нөхцөл бололцоогоор хангаж ажиллаа.

Байгаль орчин ажлын хүрээнд 2014-2016 оныг байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх чиглэлд онцгой дэвшил гаргасан жил болгон зарлаж уул уурхай байгаль орчин хамгаалах чиглэлд мөрдөгдөж буй хууль дүрэм журамдын хэрэгжилтийг сайжруулах, энэхүү үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагууд болон орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах “САЙН” санал хөтөлбөр боловсруулан МУИСургууль, Өмнөговь аймгийн байгаль орчны газартай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллаж байна.

2014 онд “Тавантолгой” ХК нь биологийн нөхөн сэргээлтэнд дөрвөн газарт нийт 5500 ш мод тарьсан. Мөн дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Байгальд эвсэг багачуудийн холбоотой хамтран Улаан эргийн талбайд улиас, хайлаас, жигд, сухай, харгана, буйлс, хармаг зэрэг 3200 мод тарьсан. Энэхүү биологийн нөхөн сэргээлтийн талбайг Цогтцэций сумын малчин Х.Туяатай хамтран ажиллах гэрээ байгуулж арчилан хамгаалж услан ургуулж байна. Эдгээр зардлуудад 26,5 сая төгрөг зарцуулсан байна.

Түүнчлэн ан амьтан хамгаалах, тандан судлах зорилгоор Цогтцэций сумын малчидтай хамтран ажиллах гэрээ байгуулж Тугийн цохио, Цавчир, Цэций уул зэрэг газруудад ажиглалт хийж байна. Энэхүү ажиглалтын үр дүнд Аргал, Янгирийн тоо өссөн байгаа юм.

2014 онд байгаль орчны хуульд заасны дагуу байгаль орчны АУДИТ-ийг өөрийн санаачлагаар “Грийн Эко Консалтинг” ХХК-аар хийлгэсэн. АУДИТ-ийн тайлангаар 127 шалгуурын 82%-ийг биелүүлсэн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын баталсан журмын дагуу 2014 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг газар дээр нь үзэж дүгнэлт гаргахаар Өмнөговь аймгийн БОГазар, МХЕГазар, Сав газрын захиргаа, Хөгжлийн бодолгын хэлтсийн бүрэлдэхүүнтэйгээр ирж ажиллан 90,8% дүгнэгдэн манай байгууллагын БО-ны үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт САЙН гэж дүгнэгдсэн.

Техник механикийн албаны хувьд нийт 116\*858 км замд 5642,7тн ачаа тээвэрлэн

72,8мян.м3 уулын цул тээвэрлэсэн үзүүлэлттэй байна. Ашиглагдах боломжгүй болж ТУЗ-ийн шийдвэр болон ИТХТ-ийн тогтоолын дагуу нийт 5 тээврийн хэрэгсэл, 2 механизмийг актлан дуудлага худалдаагаар борлуулсан. Шинээр цэвэр усны зөөврийн машин, үйлчилгээний тэрэг худалдан авч түлш шатахууны зарцуулалт, сул явалтыг багасгах үүднээс 8-р уурхайд автогражийн барилга барьж ашиглалтанд оруулаад байна.

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт

2014 онд бизнес төлөвлөгөөнд батлагдсан нийт 14 ажлаас 10 ажлыг орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу ажлыг зохион байгуулан тендер зарлах, харьцуулалт хийх зэргээр нийт 628 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

Түүнчлэн уурхайн хэтийн төлөвийг харсан нэлээдгүй ажлуудыг хийж хувь эзэмших болоод шинээр хувь нийлүүлсэн компаниудыг үүсгэн байгууллаа. БНХАУ-ын Ганцмодны боомттой холбосон нарийн төмөр зам барьж ашиглах хамтарсан “Гашуунсухайтын төмөр зам” ХХКомпанийг үүсгэн байгуулах гэрээнд 2014 оны 4-р сарын 7-нд гарын үсэг зурж Манай компани 17%-ийг эзэмшин ажил амжилттай явж байна.

Мөн Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт хилийн боомт хүртэл 239км хатуу хучилттай автозамыг Төрийн өмчит “Эрдэнэс MGL” ХХК-д шилжүүлэн, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержиресурс” ХХК-тай хамтран арчилгаа үйлчилгээг хийх “Гашуун сухайтын авто зам” ХХК-ийг байгуулан 20%-ийг тус тус эзэмшиж байна.

Энэхүү гэрээ байгуулснаар нүүрс тээврийн машинууд хатуу хучилттай замаар явж, байгаль орчинд нөлөөлөх хүндрэл арилж тээвэрлэлт хийх нөхцөл бүрдэж техникийн эвдрэл, зардал багассан боломж бүрдэж байна.

Түүнчлэн уурхайн ирээдүйд чиглэсэн томоохон ажил нь компанийн ТУЗ удаа дараа хуралдаж түүхэн чухал асуудлууд шийдвэрлэж ирсэний дотор олон жилийн маргаантай байсан ашиглалтын лицензтэй талбайгаа компанийн эзэмшилд шилжүүлэн авснаар манай нийт ашиглалтын талбай 276.91 га болж нүүрсний нөөцийн хэмжээ 194,5 орчим сая тонн болж өслөө. Мөн онд 8-р уурхайн нүүрсэнд иж бүрэн технологийн шинэжилгээ хийлгэж авлаа.

Нийгмийн хариуцлагын хүрээнд:

Ажилтан албан хаагчид гэрээт хамгаалалтын албаны ажилчдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор сэндвичэн байшинг барьж байгуулан гэр кэмпиийг татан буулгасан. Мэдээллийн эрин зуунтай хөл нийлүүлж мэдээлэл авах, өндөр хурдтайгаар шинжилгээ судалгаа, эрэл хайгуул хийх нөхцөл боломжийг хангах үүднээс интернэтийн хурдын 8 дахин нэмэгдүүлж оффисыг бүхэлд нь WIFI утасгүй интернэттэй орчин болгосон. Мөн компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэж байгаа том зүйл нь өөрийн олборлолтын өртгөөс хямд үнээр Өмнөговь аймгийн иргэдэд нүүрс нийлүүлэх, өвөлжилтийн бэлтгэлд нь тус нэмэр болох үүднээс хямд үнээс дахин хямдруулан худалдаалах, аймгийн төвийн дунд ба түүнээс доош орлоготой иргэдийн амьжиргаанд тус нэмэр болох үүднээс үнэ төлбөргүй 100км тээвэрлэн хүргэж байгаа ажлууд болно.

Сум орон нутгийг хөгжүүлэх чиглэлд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин худалдан авалтыг хийх, оновчтой төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, ард иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу санхүүгийн болон биет тусламж үзүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Хэмнэлтийн бодлогын хүрээнд:

Бизнес төлөвлөгөөнд тусгасанаар 2014 оны цалингийн сан 1,238,56 тэрбум төгрөг байсан бол гүйцэтгэлээр 1,160,56 тэрбум төгрөг болж 78,0 сая төгрөг хэмнэсэн. ТУЗ-ийн цалин 141,2 сая төгрөг ТУЗ-ийн үйл ажиллагааны зардал 368,9 сая төгрөг байсан бол гүйцэтгэлээр 180,0 сая төгрөг болж 48.9 хувиар хэмнэжээ.

Үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа сайжиртал ажилчдыг 60 хувьтай тэнцэх цалинтай чөлөө олгож сурч боловсрох, эрүүл мэнддээ анхаарахад системтэйгээр зөвлөмж зөвөлгөө өгч байна.

Хөрөнгийг үр ашигтай байршуулах, санхүүгийн хэрэгслүүдийг ашиглан боломжит хэмжээгээр ашиг олох үйл ажиллагаа явуулан банкны хүүгийн орлого 1,4 тэрбум төгрөгийн ашигтай ажиллалаа.

Үндсэн үйлдвэрлэлд зайлшгүй хэрэглэгдэх бараа бүтээгдэхүүнээс бусад зүйлсийг хэмнэх, орлуулах, хүлээгдэж болохуйц зардлыг танах зэрэг арга хэмжээ авч байна.

Байгууллагын зүгээс 2013 оны аварга шилдэг ажилчдыг Солонгос Улсын Чөжү-д аялууллаа. Үүний зэрэгцээ компанийн дотоод нөөц болоцоог ашиглан ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх фитнес, номын сан, интернэт кафе үүсгэн байгуулж, спорт залны дотоод засал чимэглэл болоод үндэсний спортыг хөгжүүлэх ажлын хүрээнд бөхийн дэвжээ, тугны суурь шинээр хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ. 2014 онд уурхайн нөхцөл байдал зах зээлээс хамааралтайгаар тийм ч таатай бус байлаа.

Ирж буй 2015 онд удирдлагын зүгээс нүүрс борлуулалт, ачаа тээвэрлэлт, гүний гаалийн асуудлуудыг шийдвэрлэх, цаашлаад нүүрсийг ангилан ялгах, баяжуулах, нүүрсний шинэ технологи нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 2015 онд нүүрсний зах зээлийн хямрал арилж компанийн борлуулалт нэмэгдэн ажилтан албан хаагчид бид бүхний сэтгэлд гал асаасан сайхан жил болно гэдэгт итгэлтэй байна.

2014 онд нэгэн үзүүр сэтгэлээр нэгдэн ажилласан хамт олон та бүхэндээ талархал илэрхийлээд ирж буй 2015 онд хийж бүтээхийн өрнүүн сэтгэлээр дүүрэн байж ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.